



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/323

Ховд

Хөрөнгө гаргах тухай.

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрүүл шүд-эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нүүр, ам судлалын сургуультай хамтран бүсийн аймгуудын шүдний хувийн эмнэлгүүдийн дунд зохион байгуулах "Шүдний оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлага" бүсийн зөвлөгөөн, сургалт, дадлагын хичээлийн үйл ажиллагааны зардалд 805 000 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд зориулагдах 805 000 төгрөг /найман зуун таван мянган/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.12 дахь заалтын "Эрүүл мэндийн эрсдлийг бууруулах" төсөл, хөтөлбөрийн зардлаас тооцож олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/-д хариуцуулсугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/323.Ch
02 01582

Аймгийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 23-ны өдрийн
А/323 дугаар захирамжийн хавсралт



ЗОРИЛТОТ БҮЛГИЙН НЭГ ИРГЭНД СУУЛГАЦ ИМПЛАНТ
СУУЛГАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын товч утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Имплантын суулгацын иж бүрдэл	1 ком	805.000	805 000

-oOo-